

БАТЛАВ: АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙД БӨГӨӨД АЖЛЫН ХЭСГИЙН
АХЛАГЧ Г.ДАМДИННЯМ



**АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ**



СТРАТЕГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ БАРИМТ БИЧИГ

ГАН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР ТӨСӨЛ

Боловсруулсан: АЖЛЫН ХЭСЭГ

2026 он

АГУУЛГА

1. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗОРИЛГО	3
2. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
3. ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	7
3.1. Эрх зүйн шаардлага	7
3.2. Санхүүгийн шаардлага	7
3.3. Үйл ажиллагааны шаардлага.....	7
3.4. Консорциум түншлэл хэлбэрээр оролцох боломж	8
3.5. Ашиг сонирхлын зөрчилгүй байх	8
4. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЕ ШАТ	9
5. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ, НОТЛОХ БАРИМТ	10
5.1. Урьдчилсан сонгон шалгаруулалтын үед ашиглах үнэлгээний аргачлал.....	10
5.2. Нарийвчилсан саналыг үнэлэх үе шатанд ашиглах үнэлгээний аргачлал	18
5.3. Нотлох баримт	20
6. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААС ХАСАХ НӨХЦӨЛ	22
7. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ИРҮҮЛЭХ	23

1 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗОРИЛГО

Энэхүү сонгон шалгаруулалтын зорилго нь Монгол Улсад хэрэгжүүлэх “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, техник технологи, менежмент, зах зээлийн туршлага бүхий стратегийн хөрөнгө оруулагчийг нээлттэй, ил тод, өрсөлдөөнт журмаар сонгон шалгаруулахад оршино.

“Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төсөл нь Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих, дотоодын ган бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортын хамаарлыг бууруулах, уул уурхай болон боловсруулах үйлдвэрлэлийн уялдаа холбоог сайжруулах, улмаар нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг бий болгох стратегийн ач холбогдол бүхий төсөл юм.

Иймд сонгон шалгаруулалтын хүрээнд төсөлд хөрөнгө оруулах сонирхолтой сонгон шалгаруулалтад оролцогчдын (цаашид оролцогч гэх) санхүүгийн чадавх, техник технологийн туршлага, үйлдвэрлэлийн менежментийн чадавх, мөн олон улсын зах зээлд ган бүтээгдэхүүн нийлүүлэх борлуулалтын тогтвортой сүлжээ зэрэг үзүүлэлтүүдийг иж бүрнээр нь үнэлж, төслийг амжилттай хэрэгжүүлэх боломжтой оролцогчдыг тодруулна.

Сонгон шалгаруулалтын эцсийн зорилго нь “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, технологи, менежмент, зах зээлийн чадавхыг бүрдүүлсэн бөгөөд Монгол Улсад эдийн засгийн хувьд хамгийн өндөр өгөөж, үр ашиг авчрахуйц санал гаргасан стратегийн хөрөнгө оруулагчтай хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээ байгуулахад оршино.

2 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.	Төслийн нэр	Ган үйлдвэрлэлийн цогцолбор
2.	Төслийн үндэслэл	Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд болох “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дотоодын түүхий эдэд тулгуурласан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтыг тусгагдсан. Энэхүү зорилтын хүрээнд Дархан-Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордуудын нөөцөд тулгуурлан жилд 1 сая тонноос багагүй хүчин чадалтай гангийн цогцолбор үйлдвэр байгуулах нь Монгол Улсын гол нэр төрлийн ган бүтээгдэхүүний хэрэгцээг хангаж, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх эдийн засгийн ач холбогдолтой юм.
3.	Төсөл хариуцагчийн товч мэдээлэл	Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам: Монгол Улсын хүнд аж үйлдвэр болон геологи, уул уурхай, газрын тосны салбарын бодлого, төлөвлөлтийг хариуцдаг бөгөөд “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийн тухайд төрийн бодлого, дэмжлэг, эрх зүйн зохицуулалтаар хангана. “Эрдэнэс Монгол” ХХК: Төрийн өмчит, уул уурхай, дэд бүтэц, эрчим хүчний стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиг үүрэг бүхий үндэсний хэмжээний толгой компани

		<p>бөгөөд 32 охин компанитай, 18,500 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа нэгдсэн менежментээр удирдан явуулж байна. Тус компани нь ашигт малтмалын ашиглалтын 69, хайгуулын 19 тусгай зөвшөөрөлтэй, улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт нүүрсний нөөцийн 22 хувь, зэсийн нөөцийн 38 хувь, жоншны нөөцийн 22 хувь, төмрийн хүдрийн нөөцийн 15%-ийг эзэмшиж, Монгол Улсын нийт экспортын орлогын 30 орчим хувийг бүрдүүлж байна. “Эрдэнэс Монгол” ХХК нь төслийн үндсэн хариуцагч бөгөөд энэхүү төсөлд оролцож буй өөрийн охин, харьяа компаниудыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.</p> <p>“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 429 дүгээр тогтоолоор “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчээр “Эрдэнэс Монгол” ХХК байхаар тогтоон, нэгдлийн бүрэлдэхүүнд ажиллуулах шийдвэр гарсан.</p> <p>Тус үйлдвэр нь хаягдал төмрийг хайлуулж, ган цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи дээр суурилан үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын металлургийн салбарын анхдагч ган үйлдвэрлэгч юм. Анх БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1990 оны 160 дугаар тогтоолоор, Монгол, Япон хоёр орны Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны гэрээний дагуу Дархан-Сэлэнгийн бүс нутгийн төмрийн хүдрийн орд газруудыг түшиглэн Дархан хотод байгуулагдсан бөгөөд Хуст-Уул, Төмөртэй, Төмөртолгойн орд газруудыг эзэмшиж байгаа ба нийт 234.8 сая тонн хүдрийн нөөцтэй. Одоогоор Төмөртэй, Төмөртолгойн ордоос жилд 2-3 сая тонн 42-45% Fe агуулгатай хүдэр олборлож, АНУ, ХБНГУ, БНХАУ зэрэг улсын уул уурхайн орчин үеийн тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон хуурай соронзон аргын үйлдвэрт боловсруулж 2.0 сая тонн 0-10 мм, 10-40 мм ширхэглэлтэй, 55-58% Fe агуулгатай бүхэл болон нунтаг баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Дээр дурдсан эзэмшил бүхий төмрийн хүдрийн ордуудаас “Ган үйлдвэрлэлийн цогцолбор”-т шаардагдах үндсэн түүхий эдээр хангана.</p> <p>“Эрдэнэс ҮТП” ХХК: Монгол Улсын Их Хурлаас 2022 онд баталсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн дагуу Засгийн газрын 2023 оны 257 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” нэгдлийн харьяанд “Эрдэнэс ҮТП” ХХК-ийг охин компани хэлбэрээр байгуулах шийдвэр гарсан. Энэ хүрээнд “Эрдэнэс Монгол” нэгдлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэрлэл, технологийн парк (ҮТП)-ийг байгуулах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй бөгөөд Дархан ҮТП-ийн хүрээнд хэрэгжих “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг зохион байгуулна.</p>
4.	Төсөл хэрэгжүүлэх байршил	Дархан-Уул аймгийн Орхон сумын нутагт байрлах 651 га талбай бүхий үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэрт
5.	Төслийн зорилго	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих; - Аж үйлдвэрийн суурь бүтцийг бэхжүүлэх;

		<ul style="list-style-type: none"> - Төмрийн хүдрийн баяжмалыг боловсруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн, дагалдах бүтээгдэхүүн үйлдвэрлэх; - Импортыг орлох, дотоодын хэрэгцээг хангах; - Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж валютын орлогыг нэмэгдүүлэх; - Дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, нутагшуулах; - Байгаль орчинд сөрөг нөлөөлөл бага үйлдвэрийг барьж, ашиглалтад оруулах; - Дараагийн шатны өндөр технологи шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх; - Орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх. 																															
6.	Санал хүлээн авах хугацаа	2026 оны 05-р сарын 11-ний өдрийн 18:00 (GMT+8)																															
7.	Төслийн хамрах хүрээ, хүчин чадал	<p>Жилд 1.0 сая тонноос багагүй хүчин чадалтай, домен зуухны технологид суурилсан гангийн иж бүрэн цогцолбор байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр - Түүхий эд бэлтгэлийн үйлдвэр (аргалж, хорголж, кокс, шохой гэх мэт) - Ган хайлуулах болон цувих үйлдвэр - Эрчим хүчний үйлдвэр - Тээвэр, логистикийн дэд бүтэц - Усан хангамж, цэвэрлэх байгууламж - Оффис, нийгмийн дэд бүтэц 																															
8.	Үндсэн түүхий эд	<p>Ган үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд: Төмрийн хүдэр, шохойн чулуу, коксжих нүүрс</p> <p style="text-align: center;">“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн эзэмшлийн ордуудын мэдээлэл</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse; text-align: center;"> <thead> <tr> <th rowspan="2">Ордын нэр, (нөөц сая.тн)</th> <th rowspan="2">Гол эрдэс</th> <th rowspan="2">Нөөцийн ангилал</th> <th rowspan="2">Ордын төрөл</th> <th colspan="3">Дундаж агуулга (%)</th> </tr> <tr> <th>Fe</th> <th>S</th> <th>P</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Төмөртолгой (25.03 сая.тн)</td> <td>Магнетит</td> <td>B+C1, C2</td> <td>Исэлдсэн, Хүхэр ихтэй</td> <td>53.56</td> <td>2.45</td> <td>0.04</td> </tr> <tr> <td>Төмөртэй (229.3 сая.тн)</td> <td>Магнетит</td> <td>B+C1, C2</td> <td>Исэлдсэн, Хүхэр багатай, ихтэй</td> <td>50.87</td> <td>0.83</td> <td>0.05</td> </tr> <tr> <td>Хуст-Уул (12.6 сая.тн)</td> <td>Магнетит</td> <td>B+C, P</td> <td>Хүхэр ихтэй</td> <td>42.25</td> <td>2.5</td> <td>0.05</td> </tr> </tbody> </table> <p>Түүхий эдийн хангалтыг Дархан-Сэлэнгийн бүсийн ордууд болон Тавантолгойн ордоос урт хугацаанд тогтвортой хангана.</p>	Ордын нэр, (нөөц сая.тн)	Гол эрдэс	Нөөцийн ангилал	Ордын төрөл	Дундаж агуулга (%)			Fe	S	P	Төмөртолгой (25.03 сая.тн)	Магнетит	B+C1, C2	Исэлдсэн, Хүхэр ихтэй	53.56	2.45	0.04	Төмөртэй (229.3 сая.тн)	Магнетит	B+C1, C2	Исэлдсэн, Хүхэр багатай, ихтэй	50.87	0.83	0.05	Хуст-Уул (12.6 сая.тн)	Магнетит	B+C, P	Хүхэр ихтэй	42.25	2.5	0.05
Ордын нэр, (нөөц сая.тн)	Гол эрдэс	Нөөцийн ангилал					Ордын төрөл	Дундаж агуулга (%)																									
			Fe	S	P																												
Төмөртолгой (25.03 сая.тн)	Магнетит	B+C1, C2	Исэлдсэн, Хүхэр ихтэй	53.56	2.45	0.04																											
Төмөртэй (229.3 сая.тн)	Магнетит	B+C1, C2	Исэлдсэн, Хүхэр багатай, ихтэй	50.87	0.83	0.05																											
Хуст-Уул (12.6 сая.тн)	Магнетит	B+C, P	Хүхэр ихтэй	42.25	2.5	0.05																											
9.	Хөрөнгө оруулалтын дэмжлэг	<ul style="list-style-type: none"> - Шалгарсан хөрөнгө оруулагчтай Монгол Улсын Засгийн газар хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, Хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгагдсан татварын болон татварын бус дэмжлэгүүдийг үзүүлнэ. - Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан дараах хөнгөлөлтүүдийг эдэлнэ. Үүнд: 																															

		<ul style="list-style-type: none"> ✓ Гаалийн татвараас 5 жил чөлөөлнө. ✓ Үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн Нэмэгдсэн өртгийн албан татвар (импорт) төлөх хугацааг 4 жил хойшлуулна. ✓ Газрын төлбөрөөс 10 жилийн хугацаанд чөлөөлнө. ✓ Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг эхний 5 жилд 100 хувь, дараагийн таван жилд 50 хувь хөнгөлнө. ✓ Гадаад ажилчдын ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлнө. ✓ Эцсийн бүтээгдэхүүний НӨАТ-ыг 0 хувиар тооцно. <p><i>Хэлэлцээрийн үед “Хөрөнгө оруулалтын тухай” хуульд заасны дагуу татварын орчныг тогтворжуулах болон бусад хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар хэлэлцэх боломжтой.</i></p>
10.	Хөрөнгө оруулж, хамтран ажиллах ерөнхий нөхцөл	<p>Төслийг хамтарсан болон бие даасан хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой бүх төрлийн хөрөнгө оруулалтын саналыг нээлттэйгээр хүлээн авна.</p> <p>Хөрөнгө оруулагч нь төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтыг бүрэн шийдвэрлэх бөгөөд техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барилга угсралт, бүтээн байгуулалт, үйлдвэрлэл явуулах, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p> <p><i>Шалгарсан хөрөнгө оруулагч этгээдтэй урт хугацаанд ордыг хамтран ашиглах нөхцөлийг хэлэлцээрийн явцад тохирох боломжтой.</i></p>
11.	Технологийн шийдэл	<ol style="list-style-type: none"> 1. Дархан-Сэлэнгийн бүс нутгийг хамарсан төмрийн хүдрийн ордын онцлогт тохирсон, бага зардлаар өндөр чанарын ган үйлдвэрлэх технологийн шийдэлтэй байх; 2. Төмрийн түүхий эд болох төмрийн хүдэрт агуулагдах металлын шинж агуулаагүй элементүүд болох хүхэр ба фосфорыг ялгаж ангилах орчин үеийн технологи ашиглах; 3. Эцсийн бүтээгдэхүүн дэх хүхрийн агууламжийг олон улсын стандартад нийцэх хэмжээнд бууруулах технологийн боломжтой байх; 4. Үндсэн тоног төхөөрөмж нь олон улсад туршигдсан, найдвартай ажиллагаатай, технологийн боломжит хэсгүүдэд хүний оролцоог бууруулж автоматжуулалтыг нэвтрүүлсэн байх; 5. Үйлдвэр, түүний үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүрээлэн буй орчин, хог хаягдал, эцсийн бүтээгдэхүүний чанарт тавигдах олон талт стандарттай байх; 6. CO₂, SO₂ болон бусад хорт хийн ялгаралтыг бууруулах шүүлтүүр, цэвэрлэгээний системтэй байх; 7. Үйлдвэрээс гарах хатуу болон шингэн хаягдлыг дахин боловсруулах боломжийг эрэлхийлэх, байгаль орчинд ээлтэй хаягдлын менежментийг хэрэгжүүлэх; 8. Үйлдвэрлэлээс үүсэх хаягдал, дайвар бүтээгдэхүүнийг дахин ашиглах, боловсруулах шийдэл санал болгох. Үүнд үйлдвэрийн дотоод хэрэглээнээс илүү гарах дулаан, хий мөн хамаарна. 9. Эрчим хүчний болон усны хэмнэлттэй технологийн шийдэлтэй байх. 10. Цогцолбор нь өөрийн тогтвортой эрчим хүчний эх үүсвэртэй, эрчим хүчний нэгдсэн системд холбогдох боломжтой байх;

		11. Үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай усны хэрэгцээг Дархан хотын хаягдал усаар хангах боломжийг эрэлхийлэх; 12. Баяжмалын чанар нь домен зуух (BF+BOF) бүхий гангийн үйлдвэрлэлд нийцсэн стандартын шаардлага хангасан байх.
12.	Байгаль орчны шаардлагууд	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын сайн туршлагад нийцсэн байх; - Тоосжилт, дуу чимээ, хорт хийн ялгаралтыг бууруулж, стандартын түвшинд барих; - Байгаль үзүүлэх сөрөг нөлөөлөл бага, ногоон үйлдвэрлэлийн зарчим тусгасан байх; - Үйлдвэрлэлийн явцад үүсэх энгийн болон аюултай хог хаягдлыг холбогдох хууль, журмын дагуу устгах, хадгалах, боловсруулах үйлдвэрийн орчныг ногоон байгууламжтай төлөвлөх, хүрээлэн буй орчин болон биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээг цогцоор нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөтэй байх.
13.	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 1 сая тонноос багагүй хүчин чадалтай гангийн үйлдвэрийг 36 сараас ихгүй хугацаанд ашиглалтад оруулсан байх.

3 ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1 ЭРХ ЗҮЙН ШААРДЛАГА

Оролцогч нь өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд байна.

Оролцогч байгууллага нь:

- үйл ажиллагаагаа хууль ёсны дагуу явуулдаг байх;
- дампуурал, төлбөрийн чадваргүй байдлын ажиллагаанд ороогүй байх;
- үйл ажиллагаа нь шүүхийн шийдвэрээр хязгаарлагдаагүй байх;
- авлига болон олон улсын мөнгө угаах ноцтой зөрчилтэй холбоотой шүүхийн шийдвэрээр буруутгагдаагүй байх;
- консорциум хэлбэрээр оролцож байгаа тохиолдолд эдгээр шаардлагыг консорциумын бүх гишүүд хангаж байх.

3.2 САНХҮҮГИЙН ШААРДЛАГА

Оролцогч байгууллага нь төслийн хөрөнгө оруулалтад оролцох санхүүгийн боломжтой байх бөгөөд дараах нөхцөлийг хангасан байна.

- тогтвортой санхүүгийн үйл ажиллагаатай байх;
- төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бүрэн бие даан шийдвэрлэх боломжтой байх.

3.3 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА

Оролцогч байгууллага нь ган үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг эсвэл холбогдох туршлагатай байна.

Үүнд:

- Хамгийн багадаа 1 сая тонн хүчин чадал бүхий гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, менежментийг хариуцаж эсхүл түүнд оролцож ажилласан байх;
- Зураг төсөл, инженерингийн мэргэжлийн туршлагатай багтай байх;
- Олон улсад худалдаа, бизнес, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай.

Оролцогч нь дараах нөхцөлийг хангасан бол давуу тал болно.

- Ган үйлдвэрлэх чиглэлээр оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн патент эзэмшигч;
- Үйлдвэрийг урт хугацаанд тогтвортой, үр ашигтай ажиллуулах, технологийн найдвартай үйл ажиллагааг хангах, нутагшуулах, тухайн үйлдвэрлэлтэй холбоотой дотоодын боловсон хүчин бэлтгэх, сургах, ажиллуулах хүний нөөцийн боломжтой байх;
- Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай технологитой байх;
- Олон улсын зах зээлд борлуулах боломжтой бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах сувагтай, туршлагатай байх;
- Олон улсад гангийн үйлдвэрийн төсөл хэрэгжүүлж байсан туршлагатай, гангийн үйлдвэрийн үйл ажиллагаа эрхэлдэг;
- Үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд үйлдвэрүүдээс гарах хорт хий, тоосжилт, шаар, шавар, бохир ус зэрэг янз бүрийн химийн бодис агуулсан хаягдлын хамгаалалт, бохирдлын хяналт, сөрөг нөлөөллийг бууруулах, дахин сэргээлтийн арга хэмжээг цогцоор нь төлөвлөлтийн эхний шатнаас системтэйгээр хэрэгжүүлэх;
- Үйлдвэрлэл технологийн паркт дараагийн шатны үйлдвэрүүдийг барьж байгуулах төлөвлөгөөтэй;
- Дотоодын хүний нөөцийг бэлтгэх, сургах, түлхүү ажиллуулах бодлоготой.

3.4 КОНСОРЦИУМ ТҮНШЛЭЛ ХЭЛБЭРЭЭР ОРОЛЦОХ БОЛОМЖ

Сонгон шалгаруулалтад консорциум хэлбэрээр оролцож болно.

Консорциум оролцох тохиолдолд:

- Консорциумын гишүүдийн бүрэлдэхүүн, оролцооны бүтэц, хувь оролцоо, чиг үүргийг тодорхой заасан байх бөгөөд консорциумын гишүүд нь нэг гишүүнийг консорциумын тэргүүлэгч оролцогчоор тодорхойлсон байна.
- Оролцогчдод тавигдах эрх зүйн, санхүүгийн болон техникийн шаардлага тус бүрийг консорциумын аль гишүүн хариуцан хангахыг тодорхой зааж, холбогдох нотлох баримтаар баталгаажуулсан байна.

3.5 АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ БАЙХ

Оролцогч байгууллага нь сонгон шалгаруулалтын үйл явцад ашиг сонирхлын зөрчилгүй байна.

Тухайлбал:

- үнэлгээний комисс
- сонгон шалгаруулалтыг зохион байгуулагч байгууллага

- төслийн зөвлөхүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй этгээд сонгон шалгаруулалтад оролцохгүй.

4 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЕ ШАТ

Стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулж хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үйл ажиллагаа нь дараах **3 үе шаттайгаар** явагдана.

I үе шат — Урьдчилсан сонгон шалгаруулалт (Pre-qualification)

Энэ шатанд оролцогчдын:

- Санхүүгийн чадавх
- Техник, технологийн туршлага
- Менежментийн туршлага
- Зах зээлийн чадавх

зэргийг үнэлж **хамгийн өндөр оноо авсан эхний 5 хүртэлх оролцогчийг** Урьдчилсан сонгон шалгаруулалтад тэнцсэн гэж үзнэ.

Үе шатны үйл явц:

1. Сонгон шалгаруулалтын зарлал нийтлэх
2. Оролцогчдын материал хүлээн авах
3. Материалын шаардлага хангалтыг шалгах
4. Үнэлгээ хийх
5. Урьдчилсан сонгон шалгаруулалтад тэнцсэн эхний 5 хүртэлх оролцогчийг тодруулах

II үе шат — Нарийвчилсан санал үнэлэх

Урьдчилсан сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчдоос дараах саналуудыг авна.

- Хөрөнгө оруулалтын санал
- Төслийн хэрэгжүүлэх төлөвлөгөө
- Технологийн шийдэл
- Санхүүжилтийн бүтэц
- Хамтын ажиллагааны нөхцөл

Энэ шатанд Монгол Улсад хамгийн өндөр өгөөжтэй байх хувилбарыг санал болгосон 1 оролцогчийг шалгаруулж **Засгийн газарт танилцуулна**.

Үе шатны үйл явц:

1. Урьдчилсан сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчдод мэдэгдлийг хүргүүлэх
2. Нарийвчилсан санал ирүүлэхтэй холбоотой 2 талын албан уулзалтыг зохион байгуулах
3. Оролцогчдын үйл ажиллагаатай танилцах
4. Оролцогч талыг нэмэлт шаардлагатай мэдээллээр хангах
5. Шаардлагатай тохиолдолд оролцогчийг төсөл хэрэгжих газар болон уурхайтай танилцах боломжоор хангах
6. Нарийвчилсан саналыг хүлээн авах

7. Материалын шаардлага хангалтыг шалгах
8. Үнэлгээ хийх
9. Хамгийн сайн гэж үнэлэгдсэн 1 саналыг тодруулах

III үе шат — Хэлэлцээр болон гэрээ байгуулах

Энэ үе шатанд сонгогдсон оролцогчтой төслийг хамтран хэрэгжүүлэхтэй холбоотой **гэрээний нөхцөлүүдийг нарийвчлан тохирох хэлэлцээр** хийнэ. Ингэхдээ “Хөрөнгө оруулалтын тухай” хууль, Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журмын дагуу зохион байгуулагдана.

Хэлэлцээрийн хүрээнд дараах асуудлуудыг тодорхойлно. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын хэмжээ болон бүтэц
- Хамтарсан компанийн бүтэц
- Санхүүжилтийн механизм
- Түүхий эдийн хангамж
- Зах зээл, борлуулалтын зохион байгуулалт
- Төслийн хэрэгжилтийн хугацаа
- Эрсдэлийн хуваарилалт
- Байгаль орчны хяналт, үүрэг хариуцлага
- Татварын орчин
- Бусад

Хэлэлцээрийн үр дүнд талууд харилцан тохиролцсон нөхцөлүүдийг үндэслэн Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын дагуу холбогдох байгууллагуудад танилцуулж **хөрөнгө оруулалтын гэрээг байгуулна.**

5 ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ, НОТЛОХ БАРИМТ

5.1 УРЬДЧИЛСАН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЕД АШИГЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Үнэлгээний зарчим

Сонгон шалгаруулалтын эхний шатанд оролцогчдын санхүүгийн чадавх, техник технологийн чадавх, менежментийн туршлага болон зах зээлийн чадавхыг олон улсын жишигт нийцсэн онооны системээр үнэлнэ.

Үнэлгээнд дараах зарчмуудыг баримтална.

- Ил тод, шударга байх
- Бүх оролцогчдод тэгш боломж олгох
- Баримт нотолгоонд суурилсан байх
- Олон улсад төсөл хэрэгжүүлсэн туршлагыг харгалзан үнэлэх
- Төслийн амжилттай хэрэгжилтийг хангах чадавхыг тодорхойлох

Үнэлгээний нийт оноо **100 оноо** байна.

Үнэлгээний бүтэц

Үнэлгээний шалгуур	Оноо
Санхүүгийн чадавх	30
Техник, технологийн чадавх	30
Менежментийн чадавх	20
Зах зээлийн чадавх	20
Нийт	100

Дараагийн шатанд шалгарах оролцогч нь 70 буюу түүнээс дээш оноог авсан байх шаардлагатай бөгөөд 70 онооноос дээш авсан оролцогчдыг авсан онооны дагуу эрэмбэлэн эхний 5 хүртэлх оролцогчдыг урьдчилсан сонгон шалгаруулалтад тэнцсэн гэж үзнэ.

Санхүүгийн чадавх (30 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага төслийн их хэмжээний хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх бодит боломжтой эсэхийг тодорхойлоход чиглэнэ. Санхүүгийн чадавхыг тодорхойлохдоо сүүлийн 3 жилийн санхүүгийн баталгаажсан тайланд үндэслэнэ.

№	Үзүүлэлт	Тайлбар	Оноо
1	Өөрийн хөрөнгийн хэмжээ (Equity)	Компанийн бодит санхүүгийн чадавхыг илэрхийлнэ.	10
2	Өрийн харьцаа (Debt-to-Equity Ratio)	Компанийн өрийн ачааллыг үнэлнэ.	10
3	Ашигт ажиллагаа (Net profit Margin)	Сүүлийн 3 жилийн ашигт ажиллагааг үнэлнэ.	5
4	Мөнгөн урсгал (Cash Flow Capacity)	Operating cash flow болон хөрөнгө босгох боломжийг илэрхийлнэ	5
Нийт			30

Өөрийн хөрөнгийн хэмжээ (10 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллагын санхүүгийн суурь чадавх болон төслийн хөрөнгө оруулалтад өөрийн хөрөнгөөр оролцох боломжийг тодорхойлох зорилготой. Өөрийн хөрөнгийн хэмжээ их байх тусам тухайн байгууллага том хэмжээний хөрөнгө оруулалтын төсөлд оролцох санхүүгийн боломж өндөр гэж үзнэ. Энэхүү үнэлгээг компанийн сүүлийн жилийн баталгаажсан санхүүгийн тайланд үндэслэнэ.

Өөрийн хөрөнгө	Оноо
3 тэрбум USD түүнээс дээш	10
1–3 тэрбум USD	8
500 сая – 1 тэрбум USD	6
<500 сая USD	2

Өрийн харьцаа (Debt-to-Equity Ratio) (10 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллагын санхүүгийн тогтвортой байдал болон өрийн ачааллын түвшнийг үнэлэхэд чиглэнэ. Өрийн хэмжээ хэт өндөр байх нь компанийн санхүүгийн эрсдэлийг нэмэгдүүлж, том хэмжээний шинэ хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх боломжийг бууруулдаг. Энэхүү үнэлгээг компанийн сүүлийн жилийн баталгаажсан санхүүгийн тайланд үндэслэнэ.

Харьцаа	Оноо
<1.0	10
1.0 – 1.5	8
1.5 – 2.0	5
>2.0	2

Debt to Equity Ratio = Total Liability / Equity

Ашигт ажиллагаа (Net Profit Margin) (5 оноо)

Net Profit Margin нь компанийн нийт орлогоос хэдэн хувь нь цэвэр ашиг болж байгааг илэрхийлдэг бөгөөд компанийн үйл ажиллагааны үр ашиг, зардлын удирдлага болон санхүүгийн тогтвортой байдлыг харуулдаг.

Net Profit Margin (3 жилийн дундаж)	Оноо
≥ 10 %	5
8 – 10 %	4
5 – 8%	3
0 – 5%	2

Net Profit Margin = Net Profit / Total Revenue

- Net Profit Margin-ийг сүүлийн 3 жилийн дундаж үзүүлэлтээр тооцно.
- Санхүүгийн мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлангаар баталгаажсан байна.
- Хэрэв сүүлийн 3 жилийн хугацаанд алдагдалтай жил байгаа бол тухайн үзүүлэлтийн оноог бууруулж үнэлж болно.

Мөнгөн урсгал (Cash Flow Capacity) – 5 оноо

Энэ шалгуур нь оролцогч байгууллагын үйл ажиллагаанаас бий болж буй мөнгөн урсгал нь том хэмжээний хөрөнгө оруулалтын төсөлд оролцох санхүүгийн боломжтой эсэхийг үнэлэхэд чиглэнэ. Тогтвортой бөгөөд өндөр хэмжээний мөнгөн урсгалтай компаниуд нь төслийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, өр төлбөрийн үүргээ биелүүлэх, төслийн хэрэгжилтийн явцад шаардлагатай нэмэлт санхүүжилтийг татах боломж илүү байдаг.

Үнэлгээг оролцогч байгууллагын сүүлийн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан-д үндэслэн тооцсон үйл ажиллагааны мөнгөн урсгал (Operating Cash Flow)-ын дундаж үзүүлэлтээр хийнэ.

Operating Cash Flow (3 жилийн дундаж)	Оноо
≥ 5 тэрбум USD	5
2 – 5 тэрбум USD	4
500 сая – 2 тэрбум USD	3
<500 сая USD	2

Техник, технологийн чадавх (30 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага ган үйлдвэрлэлийн томоохон төслийг техник, технологийн хувьд амжилттай хэрэгжүүлэх туршлага, инженерийн чадавх болон байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх боломжийг үнэлэхэд чиглэнэ.

№	Үзүүлэлт	Тайлбар	Оноо
1	Гангийн үйлдвэр барьж ашиглалтад оруулсан туршлага	Integrated steel plant төслийн туршлага	10
2	Технологийн түвшин	Орчин үеийн ган үйлдвэрлэлийн технологи хэрэглээ	10
3	Байгаль орчинд ээлтэй технологи (ESG)	Нүүрстөрөгч бууруулах болон байгальд ээлтэй технологи	5
4	Инженер, технологийн чадавх	Төслийн инженер, технологийн багийн чадавх	5
Нийт			30

Гангийн үйлдвэр барьж ашиглалтад оруулсан туршлага (10 оноо)

Энэ шалгуур нь оролцогч нь гангийн үйлдвэр барьж ашиглалтад оруулсан бодит туршлагатай эсэхийг үнэлнэ.

Үнэлгээнд дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

- Олон улсад хэрэгжүүлсэн integrated steel plant төслийн туршлага
- Төслийн хүчин чадал

Олон улсад гангийн үйлдвэрийн төсөл хэрэгжүүлсэн туршлага		Хэрэгжүүлсэн төслийн хүчин чадал	
Туршлага	Оноо	Хүчин чадал	Оноо
2 ба түүнээс дээш улс оронд гангийн үйлдвэрийн төсөл хэрэгжүүлсэн (Өөрийн улсыг оруулахгүй)	4	≥ 5 сая тонн ган	6
1 гадаадын улсад төсөл хэрэгжүүлсэн	3	3 – 5 сая тонн	4
Зөвхөн дотоодын төсөл хэрэгжүүлсэн	2	1 – 3 сая тонн	3
		< 1 сая тонн	2

*Хэрэгжүүлсэн төслийн хүчин чадлыг тооцохдоо олон үйлдвэрүүдийн нийлбэрээр бус зөвхөн хэрэгжүүлж байсан хамгийн том төслийн хүчин чадлыг авч үзнэ.

Технологийн түвшин (10 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага орчин үеийн ган үйлдвэрлэлийн технологи ашиглах чадвартай эсэхийг үнэлнэ.

Технологийн түвшин	Оноо
Төмрийн хүдрийн олборлолт, баяжуулалт шатнаас нь эхлэн ган үйлдвэрлэх хүртэлх бүрэн цогц үйлдвэрлэлийг явуулдаг	5
BF + BOF технологи ашигладаг	1
Үйлдвэрийн автоматжуулалтын систем (process automation) нэвтрүүлсэн	1
Дайвар бүтээгдэхүүнийг боловсруулж ашигладаг эсэх /Slag, gas etc/	1
Үйлдвэрлэлийн нэгдсэн хяналтын систем нэвтрүүлсэн	1
Эрчим хүчний үр ашиг болон хаягдал дулаан ашиглах технологи (Waste Heat Recovery / Energy Efficiency) нэвтрүүлсэн	1
Нийт	10

Энэхүү үнэлгээг хийхэд оролцогч нь шаардлагатай мэдээллийг ирүүлэх бөгөөд үүнд дээрх шалгууруудыг хангаж байгаа тухай одоо ашиглаж буй технологийн талаарх танилцуулга байна.

Байгаль орчинд ээлтэй технологи (ESG) (5 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага байгаль орчинд ээлтэй технологи, нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах шийдлийг нэвтрүүлсэн туршлагатай эсэхийг үнэлнэ.

Үнэлгээнд дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

- low-carbon steel технологи
- energy efficiency technology
- waste heat recovery
- emission control technology
- environmental management system

Үзүүлэлт	Оноо
Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах технологи нэвтрүүлсэн (low-carbon steel, CO ₂ reduction technology)	2
Үйлдвэрийн хий, тоосжилт болон бохирдлыг бууруулах орчин үеийн шүүлтүүр, цэвэршүүлэх технологи ашигладаг	1
Байгаль орчны менежментийн тогтолцоо нэвтрүүлсэн (жишээ нь ISO 14001)	1
ESG, SDG тайлан гаргадаг эсэх	1
Нийт	5

Оролцогч нь дээрх үзүүлэлтүүдийг хангаж буй эсэх талаар нотлох баримтыг ирүүлнэ.

Инженер, технологийн чадавх (5 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага гангийн үйлдвэрийн томоохон төслийг инженерийн хувьд төлөвлөх, хэрэгжүүлэх, ашиглалтад оруулах мэргэжлийн багтай эсэхийг үнэлнэ.

Үнэлгээнд дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

- инженерийн багийн туршлага
- металлургийн мэргэжилтнүүд
- төслийн инженерийн чадавх
- технологийн лиценз, ноу-хау

Үнэлгээг дараах 4 үндсэн үзүүлэлтээр хийнэ. Тухайн үзүүлэлт байгаа тохиолдолд хамаарах оноог өгч, байхгүй тохиолдолд 0 оноо өгч нийлбэрээр үнэлгээг тодорхойлно.

№	Үзүүлэлт	Оноо
1	Гангийн үйлдвэрийн зураг төсөл, инженерчлэлийн туршлагатай инженерийн багтай	2
2	Томоохон аж үйлдвэрийн төслийн инженер, төслийн менежментийн туршлагатай багтай	1
3	Ган үйлдвэрлэлийн технологийн лиценз, ноу-хау эзэмшдэг	2
	Нийт	5

Менежментийн чадавх (20 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага гангийн үйлдвэрийн үйл ажиллагааг үр ашигтай удирдах, үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангах, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай менежментийн туршлагатай эсэхийг үнэлэхэд чиглэнэ.

Үнэлгээнд оролцогч байгууллагын:

- гангийн үйлдвэрлэлийн хүчин чадал
- үйлдвэрийн үйл ажиллагааны туршлага
- үйлдвэрийн менежментийн тогтолцоо
- олон улсын үйл ажиллагааны туршлага зэргийг харгалзан үзнэ.

№	Үзүүлэлт	Тайлбар	Оноо
1	Ган үйлдвэрлэлийн хүчин чадал	Оролцогч байгууллагын одоогийн ган үйлдвэрлэлийн хэмжээ болон салбар дахь үйл ажиллагааны цар хүрээг илэрхийлнэ	7
2	Гангийн үйлдвэрийн үйл ажиллагааны туршлага	Гангийн үйлдвэрийг тогтвортой ажиллуулж ирсэн хугацаа болон үйл ажиллагааны туршлагыг илэрхийлнэ	5
3	Үйлдвэрийн менежментийн тогтолцоо	Үйлдвэрийн үйл ажиллагааг удирдах дотоод менежментийн систем болон стандартууд	4
4	Олон улсын үйл ажиллагааны туршлага	Олон улсын зах зээлд үйл ажиллагаа явуулж байсан туршлага болон хамтын ажиллагааны хүрээ	4
	Нийт		20

Ган үйлдвэрлэлийн хүчин чадал (7 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллагын одоогийн ган үйлдвэрлэлийн хүчин чадал болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны цар хүрээг үнэлэхэд чиглэнэ. Том хэмжээний үйлдвэрлэлийн хүчин чадалтай компаниуд нь гангийн үйлдвэрийн үйл ажиллагааг үр ашигтай удирдах, үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангах туршлага, менежментийн чадавх өндөртэй гэж үзнэ.

Үнэлгээг оролцогч байгууллагын сүүлийн үеийн үйлдвэрлэлийн хүчин чадлын мэдээлэлд үндэслэн хийнэ.

Жилийн ган үйлдвэрлэлийн хүчин чадал	Оноо
≥ 20 сая тонн	7
10 – 20 сая тонн	5
5 – 10 сая тонн	3
1 – 5 сая тонн	2

Гангийн үйлдвэрийн үйл ажиллагааны туршлага (5 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага гангийн үйлдвэрийг удаан хугацаанд тогтвортой ажиллуулж ирсэн туршлагатай эсэхийг үнэлнэ. Удаан хугацаанд үйлдвэр ажиллуулсан туршлага нь тухайн байгууллага үйлдвэрлэлийн технологийн горим, засвар үйлчилгээ, үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг удирдах чадвартай болохыг илэрхийлнэ.

Үнэлгээг оролцогч байгууллагын гангийн үйлдвэрийн үйл ажиллагааны нийт хугацаанд үндэслэн хийнэ.

Туршлага	Оноо
≥ 40 жил	5
20 – 40 жил	4
10 – 20 жил	3
< 10 жил	1

Үйлдвэрийн менежментийн тогтолцоо (4 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага үйлдвэрийн үйл ажиллагааг үр ашигтай удирдах, үйлдвэрлэлийн чанар, аюулгүй байдал болон дотоод хяналтыг хангах менежментийн системийг нэвтрүүлсэн эсэхийг үнэлнэ.

Үнэлгээг дараах үзүүлэлтүүдээр хийнэ. Тухайн үзүүлэлт байгаа тохиолдолд 1 оноо, байхгүй бол 0 оноо өгч нийлбэрээр үнэлнэ.

Үзүүлэлт	Оноо
Чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001 гэх мэт) хэрэгжүүлдэг	1
Үйлдвэрлэлийн менежментийн систем (production management system)	1
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо	1
Дотоод аудит болон эрсдэлийн удирдлагын тогтолцоо	1
Нийт	4

Олон улсын үйл ажиллагааны туршлага (4 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага олон улсын зах зээлд үйл ажиллагаа явуулж байсан туршлага, хамтын ажиллагааны цар хүрээг үнэлэхэд чиглэнэ. Олон улсын туршлагатай компаниуд нь томоохон аж үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай менежментийн туршлага, зах зээлийн ойлголт, олон улсын стандартын дагуу ажиллах чадвартай байдаг.

Үнэлгээг дараах үзүүлэлтүүдээр хийнэ.

Үзүүлэлт	Оноо
Олон улсад гангийн үйлдвэр эзэмшдэг эсвэл ажиллуулдаг	2
Ган бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд экспортолдог	1
Олон улсын түншлэл, хамтын ажиллагааны туршлагатай	1
Нийт	4

Зах зээлийн чадавх (20 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага ган бүтээгдэхүүнийг олон улсын болон бүс нутгийн зах зээлд тогтвортой нийлүүлэх, борлуулах сүлжээтэй эсэх, борлуулалтын туршлага болон зах зээлийн байр суурийг үнэлэхэд чиглэнэ.

Гангийн үйлдвэрлэлийн төслийн амжилт нь зөвхөн үйлдвэрлэлийн хүчин чадлаас гадна бүтээгдэхүүнийг зах зээлд тогтвортой нийлүүлэх боломж, борлуулалтын суваг, хэрэглэгчийн сүлжээтэй шууд холбоотой байдаг. Иймээс оролцогч байгууллагын экспортын туршлага, олон улсын борлуулалтын сүлжээ, зах зээлийн туршлага, урт хугацааны хэрэглэгчийн харилцаа зэрэг хүчин зүйлсийг харгалзан үнэлнэ.

№	Үзүүлэлт	Тайлбар	Оноо
1	Ган бүтээгдэхүүний экспортын туршлага	Олон улсын зах зээлд ган бүтээгдэхүүн нийлүүлж байсан туршлага	7
2	Олон улсын борлуулалтын сүлжээ	Бүс нутгийн болон дэлхийн зах зээлд борлуулалтын тогтвортой сувагтай эсэх	5
3	Урт хугацааны хэрэглэгч, худалдан авагчийн сүлжээ	Ган бүтээгдэхүүний тогтвортой худалдан авагчид болон түншүүдтэй эсэх	4
4	Зах зээлийн судалгаа, борлуулалтын стратеги	Зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, борлуулалтын бодлого боловсруулах чадавх	4
Нийт			20

Ган бүтээгдэхүүний экспортын туршлага (7 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага ган бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд нийлүүлж байсан бодит туршлагатай эсэхийг үнэлэхэд чиглэнэ. Экспортын туршлага нь тухайн байгууллага олон улсын худалдаа, логистик, бүтээгдэхүүний стандарт, хэрэглэгчийн шаардлагыг хангах туршлагатай болохыг илэрхийлнэ.

Үнэлгээг оролцогч байгууллагын жилийн ган бүтээгдэхүүний экспортын хэмжээд үндэслэн хийнэ.

Жилийн экспортын хэмжээ	Оноо
≥ 10 сая тонн	7
5 – 10 сая тонн	5
1 – 5 сая тонн	3
< 1 сая тонн	1

Олон улсын борлуулалтын сүлжээ (5 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага олон улсын болон бүс нутгийн зах зээлд тогтвортой борлуулалтын сүлжээтэй эсэхийг үнэлэхэд чиглэнэ. Борлуулалтын өргөн сүлжээтэй компаниуд нь ган бүтээгдэхүүнийг янз бүрийн зах зээлд нийлүүлэх, зах зээлийн эрсдэлийг бууруулах, борлуулалтын тогтвортой байдлыг хангах боломжтой байдаг.

Үзүүлэлт	Оноо
3 ба түүнээс дээш бүс нутагт (жишээ: Ази, Европ, Америк) борлуулалтын сүлжээтэй	5
2 бүс нутагт борлуулалтын сүлжээтэй	4
1 бүс нутагт борлуулалтын сүлжээтэй	2
Зөвхөн дотоодын зах зээл	1

Урт хугацааны хэрэглэгч, худалдан авагчийн сүлжээ (4 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага ган бүтээгдэхүүний тогтвортой худалдан авагчид болон үйлдвэрлэлийн хэрэглэгчидтэй эсэхийг үнэлнэ. Урт хугацааны худалдан авагчтай байх нь бүтээгдэхүүний борлуулалтын тогтвортой байдал, зах зээлийн эрсдэлийг бууруулах чухал хүчин зүйл болдог.

Үнэлгээг дараах шалгууруудаар хийнэ. Тухайн үзүүлэлт байгаа бол бүрэн оноо, байхгүй бол 0 оноо өгнө.

Үзүүлэлт	Оноо
Урт хугацааны борлуулалтын гэрээ (offtake agreement) байгуулсан	2
Тогтвортой үйлдвэрлэлийн хэрэглэгчид болон түншүүдтэй	1
Олон улсын томоохон худалдан авагчидтай	1
Нийт	4

Зах зээлийн судалгаа, борлуулалтын стратеги (4 оноо)

Энэ шалгуур нь оролцогч байгууллага ган бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох, борлуулалтын урт хугацааны стратеги боловсруулах чадавхтай эсэхийг үнэлэхэд чиглэнэ.

Үнэлгээг дараах шалгууруудаар хийнэ. Тухайн үзүүлэлт байгаа бол 1 оноо, байхгүй бол 0 оноо өгнө.

Үзүүлэлт	Оноо
Олон улсын зах зээлийн судалгаа тогтмол хийдэг	1
Борлуулалтын стратеги, төлөвлөгөө боловсруулсан	1
Бүс нутгийн зах зээлийн эрэлтэд тулгуурласан бүтээгдэхүүний бүтэцтэй	1
Олон улсын маркетинг, борлуулалтын багтай	1
Нийт	4

5.2 НАРИЙВЧИЛСАН САНАЛЫГ ҮНЭЛЭХ ҮЕ ШАТАНД АШИГЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Энэ үе шатанд урьдчилсан сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчдоос төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан санал (Final Investment Proposal)-ыг ирүүлж үнэлнэ.

Нарийвчилсан саналд оролцогч байгууллагууд төслийн хөрөнгө оруулалтын бүтэц, санхүүжилтийн эх үүсвэр, технологийн шийдэл, төслийн хэрэгжилтийн төлөвлөгөө, үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээгдэхүүний зах зээл, эдийн засгийн үр ашиг зэрэг асуудлуудыг дэлгэрэнгүй тусгасан байна.

Энэхүү үе шатны үнэлгээний зорилго нь оролцогчдоос ирүүлсэн саналуудыг эдийн засаг, санхүү, технологийн үзүүлэлтүүдэд үндэслэн харьцуулан үнэлж, Монгол Улсад хамгийн өндөр өгөөжтэй, үр ашигтай хувилбарыг тодорхойлох явдал юм.

Үнэлгээний зарчим

Нарийвчилсан саналын үнэлгээг дараах зарчмыг баримтлан хийнэ.

- Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нийт үр өгөөжийг харгалзан үнэлэх
- Төслийн санхүүгийн тогтвортой байдал, хэрэгжих боломж-ийг үнэлэх
- Технологийн шийдэл, үйлдвэрлэлийн үр ашиг, байгаль орчны нөлөөллийг харгалзан үзэх
- Төслийн урт хугацааны тогтвортой ажиллагаа болон зах зээлийн боломжийг үнэлэх

Үнэлгээг оролцогч байгууллагуудаас ирүүлсэн нарийвчилсан санхүүгийн болон техникийн тооцоололд үндэслэн хийнэ.

Нарийвчилсан саналын үнэлгээний үндсэн шалгуурууд

Нарийвчилсан саналд дараах үндсэн асуудлуудыг харгалзан үнэлгээ хийнэ.

1. Хөрөнгө оруулалтын санал

Оролцогч байгууллагын санал болгож буй:

- нийт хөрөнгө оруулалтын хэмжээ
- хөрөнгө оруулалтын бүтэц, хувь эзэмшил
- өөрийн хөрөнгө болон зээлийн харьцаа
- санхүүжилтийн эх үүсвэр зэргийг үнэлнэ.

2. Төслийн санхүүгийн үр ашиг

Төслийн эдийн засгийн үр ашгийг дараах үзүүлэлтүүдээр харгалзан үнэлнэ.

- төслийн цэвэр өнөөгийн үнэ цэнэ (NPV)
- дотоод өгөөжийн хувь (IRR)
- төслийн мөнгөн урсгал
- хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа
- төслөөс хүртэх Монголын талын өгөөж

3. Монгол Улсад үзүүлэх эдийн засгийн үр өгөөж

Төслийн хэрэгжилт нь Монгол Улсын эдийн засагт дараах байдлаар үзүүлэх үр нөлөөг харгалзан үнэлнэ.

- ажлын байр бий болгох боломж
- мэргэжилтэн бэлтгэх боломж
- дотоодын түүхий эд ашиглах боломж
- татвар болон төсөвт төвлөрүүлэх орлого
- дотоодын үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээнд үзүүлэх нөлөө

4. Технологийн шийдэл болон үйлдвэрлэлийн үр ашиг

Оролцогч байгууллагын санал болгож буй:

- технологийн шийдэл
- үйлдвэрлэлийн хүчин чадал
- үйлдвэрлэлийн үр ашиг
- байгаль орчны нөлөөлөл зэргийг харгалзан үнэлнэ.

5. Төслийн хэрэгжилтийн төлөвлөгөө

Төслийг хэрэгжүүлэх:

- зураг төслийн хугацаа
- барилга угсралтын хугацаа
- үйлдвэрлэлийг эхлүүлэх хугацаа зэргийг харгалзан үнэлнэ.

Эцсийн сонголт

Нарийвчилсан саналын үнэлгээний дүнд оролцогчдоос ирүүлсэн саналуудыг харьцуулан дүгнэж, Монгол Улсад эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг бий болгох, хэрэгжих боломжтой, тогтвортой санал тавьсан оролцогчийг шалгаруулна.

Шалгарсан оролцогчтой төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой хэлэлцээрийг хийж, хөрөнгө оруулалтын болон хамтын ажиллагааны гэрээ байгуулах ажиллагааг зохион байгуулна.

5.3 НОТЛОХ БАРИМТ

Сонгон шалгаруулалтын үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллийг баталгаажуулах зорилгоор оролцогч байгууллага нь энэхүү баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтүүдийг нотлох шаардлагатай баримт бичиг, мэдээллийг бүрдүүлж ирүүлнэ.

Ирүүлсэн баримт бичиг нь оролцогч байгууллагын санхүүгийн чадавх, техник технологийн туршлага, менежментийн чадавх болон зах зээлийн боломж зэрэг үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг нотлох үндэслэл болно.

Оролцогч байгууллага дараах үндсэн баримт бичгийг ирүүлнэ. Ирүүлсэн материалууд нь **Англи хэл** дээр байна.

1. Байгууллагын ерөнхий мэдээлэл

- байгууллагын танилцуулга
- компанийн бүтэц болон хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл
- үйл ажиллагааны үндсэн чиглэл
- олон улсын үйл ажиллагааны мэдээлэл

2. Санхүүгийн баримт бичиг

Санхүүгийн чадавхыг үнэлэхэд оролцогч байгууллага дараах баримт бичгийг ирүүлнэ.

- сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан

Шаардлагатай тохиолдолд үнэлгээний комисс нэмэлт санхүүгийн мэдээлэл ирүүлэхийг хүсэж болно.

3. Техник, технологийн туршлагыг нотлох баримт

Техник, технологийн чадавхыг үнэлэхэд оролцогч байгууллага дараах мэдээллийг ирүүлнэ.

- хэрэгжүүлсэн гангийн үйлдвэрийн төслүүдийн жагсаалт
- төслийн товч танилцуулга
- төслийн хүчин чадал
- төслийн хэрэгжилтийн хугацаа
- төслийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн үүрэг (хөрөнгө оруулагч, оператор, EPC гэх мэт)
- ашиглаж буй технологийн тайлбар
- инженер техникийн ажилчдын талаарх мэдээлэл

Мөн оролцогч байгууллага үнэлгээ хийхэд шаардлагатай нэмэлт мэдээллүүдийг ирүүлнэ.

4. Байгаль орчны технологийг нотлох баримт

Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлсэн байдлыг нотлох зорилгоор оролцогч байгууллага дараах мэдээллийг ирүүлнэ.

- байгаль орчны менежментийн тогтолцооны гэрчилгээ
- хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах технологийн мэдээлэл
- үйлдвэрлэлийн хаягдал болон бохирдлыг бууруулах технологийн тайлбар
- ESG болон тогтвортой хөгжлийн тайлан (хэрэв байгаа бол)

5. Менежментийн чадавхыг нотлох баримт

Оролцогч байгууллага менежментийн чадавхаа нотлох зорилгоор дараах мэдээллийг ирүүлнэ.

- гангийн үйлдвэрийн үйл ажиллагааны мэдээлэл
- үйлдвэрлэлийн хүчин чадлын мэдээлэл
- үйлдвэрийн менежментийн тогтолцооны талаарх мэдээлэл
- төслийн удирдлагын багийн танилцуулга

6. Зах зээлийн чадавхыг нотлох баримт

Зах зээлийн чадавхыг үнэлэхэд оролцогч байгууллага дараах мэдээллийг ирүүлнэ.

- ган бүтээгдэхүүний борлуулалтын мэдээлэл
- экспортын хэмжээ
- борлуулалтын гол зах зээлүүд
- урт хугацааны худалдан авагч болон түнш байгууллагуудын мэдээлэл

Нэмэлт тайлбар

Оролцогч байгууллага нь ирүүлсэн мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна. Хэрэв ирүүлсэн мэдээлэл буруу, төөрөгдүүлсэн эсвэл нотлох баримтгүй болох нь тогтоогдвол тухайн оролцогчийг сонгон шалгаруулалтаас хасах үндэслэл болно.

Үнэлгээний комисс шаардлагатай гэж үзвэл оролцогчдоос нэмэлт тайлбар, баримт бичиг ирүүлэхийг хүсэж болно.

Оролцогч нь шаардлагатай тохиолдолд мэдээллийг ирүүлэхээс өмнө хүлээн авагч этгээдтэй нууцын гэрээг байгуулж болно.

6 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААС ХАСАХ НӨХЦӨЛ

Сонгон шалгаруулалтын үе шатанд сонирхогч этгээдээс ирүүлсэн материалыг шалгах явцад дараах нөхцөл үүссэн тохиолдолд тухайн оролцогчийг сонгон шалгаруулалтаас хасна.

6.1. Материал бүрэн ирүүлээгүй

Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагатай материал, мэдээллийг бүрэн ирүүлээгүй, эсхүл баримт бичиг дутуу, тодорхой бус, шаардлагад нийцээгүй тохиолдолд оролцогчийг үнэлгээнд оруулахгүй.

6.2. Худал эсхүл төөрөгдүүлсэн мэдээлэл ирүүлсэн

Ирүүлсэн материалд:

- худал мэдээлэл
- бодит байдлыг төөрөгдүүлсэн тайлбар
- баримт бичгийг санаатайгаар буруу танилцуулсан нь тогтоогдсон тохиолдолд тухайн оролцогчийг сонгон шалгаруулалтаас хасна.

6.3. Санхүүгийн ноцтой эрсдэлтэй

Оролцогч байгууллага:

- дампуурлын ажиллагаанд орсон
- төлбөрийн чадваргүй болсон
- шүүхийн шийдвэрээр үйл ажиллагаа нь хязгаарлагдсан бол сонгон шалгаруулалтаас хасна.

6.4. Ашиг сонирхлын зөрчилтэй

Сонгон шалгаруулалтын үйл явцад оролцож буй:

- үнэлгээний комисс
- зохион байгуулагч байгууллага
- төслийн зөвлөхүүдтэй ашиг сонирхлын зөрчил илэрсэн тохиолдолд тухайн оролцогчийг хасна.

6.5. Хууль эрх зүйн ноцтой зөрчилтэй

Оролцогч байгууллага эсхүл түүний удирдлага:

- авлига
- санхүүгийн залилан
- хууль бус бизнесийн үйл ажиллагаа зэрэг ноцтой зөрчилд холбогдож шүүхийн шийдвэр гарсан бол тухайн оролцогчийг сонгон шалгаруулалтаас хасна.

6.6. Олон улсын хоригт багтсан байгууллага

Оролцогч байгууллага болон түүний хувьцаа эзэмшигч нь:

- олон улсын хориг
- санхүүгийн хориг
- терроризмын санхүүжилтийн жагсаалт зэрэгт багтсан тохиолдолд тухайн оролцогчийг шууд хасна.

6.7. Сонгон шалгаруулалтын журам зөрчсөн

Сонгон шалгаруулалтын явцад:

- хууль бус нөлөөлөл үзүүлэх
- авлига санал болгох
- үнэлгээний үйл явцад нөлөөлөх оролдлого хийх зэрэг үйлдэл илэрсэн тохиолдолд тухайн оролцогчийг сонгон шалгаруулалтаас хасна.

6.8. Оролцогчдод тавигдах ерөнхий шаардлагыг хангаагүй

Оролцогч нь сонгон шалгаруулалтад оролцогчдод тавигдах ерөнхий шаардлагыг хангаагүй тохиолдолд ирүүлсэн саналыг үнэлгээнд оруулахгүй.

7 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ИРҮҮЛЭХ

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй этгээд нь дараах баримт бичгийг бүрдүүлэн 2026 оны 05-р сарын 11-ний өдрийн 18:00 (GMT+8) цагаас өмнө industry@mmhi.gov.mn цахим хаягаар илгээх бөгөөд баримт бичгийн эх хувийг битүүмжилж доорх хаягаар ирүүлнэ. *(Эх хувиар ирүүлж буй баримт бичгийг 2 хувь үйлдэн дээрх заасан хугацаанаас өмнө илгээсэн байна.)*

Хаяг: МОНГОЛ УЛС, 15160, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж-5/1, Засгийн газрын II-р байр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Аж үйлдвэрийн бодлогын газар, 402 тоот

Оролцогч нь дараах баримт бичгийг бэлтгэн ирүүлнэ:

- Стратегийн хөрөнгө оруулагчийн сонгон шалгаруулалтад оролцох, төслийн хөрөнгө оруулалтыг бие даан эсвэл түншлэгч этгээдийн хамт бүрэн шийдвэрлэх боломжтой тухай илэрхийлсэн албан захиа;
- Оролцогчдод тавигдах ерөнхий шаардлагыг хангаж буй талаарх мэдэгдэл, нотлох баримтын хамт;

- Энэхүү баримт бичгийн 5.3-т заасан үнэлгээ хийхэд шаардлагатай нотлох баримтууд;
- Оролцогчийн зүгээс ирүүлэх шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт мэдээлэл.

Сонгон шалгаруулалтад орох хүсэлт, баримт бичгийг **Англи хэл** дээр бэлтгэн ирүүлэх бөгөөд үнэлгээ хийх боломжгүй дутуу мэдээлэл ирүүлсэн, цахимаар болон цаасаар ирүүлсэн баримт бичгүүд нь зөрүүтэй тохиолдолд үнэлгээг бууруулах, эсхүл үнэлэхээс татгалзах шалтгаан болж болно.

Жич: Оролцогч нь цаасан хэлбэрээр битүүмжилж ирүүлсэн 2 хувь бичиг баримтыг “Эх хувь”, “Хуулбар хувь” гэж ялган тэмдэглэж ирүүлнэ.

Сонгон шалгаруулалттай холбоотой тодруулах, нэмэлт мэдээлэл авах тохиолдолд gankhuyag@erdenesitp.mn, byambajav.b@mmhi.gov.mn цахим хаягуудаар холбогдох боломжтой.

--o0o--